



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 10

Арвайхээр

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн 2025-2028 онд хэрэгжүүлэх "Стратеги төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.
2. Стратеги төлөвлөгөөг чанар үр дүнтэй үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, үр дүнг Удирдах зөвлөлийн хуралд жил бүр тайлагнахыг сургуулийн Захирал (С.Санчир)-д үүрэг болгосугай.
3. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсвийн зохих зүйл ангиас зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч, эдийн засагч (С.Хандсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



О.ГАНСҮХ



БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ХАРЬЯА  
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

## **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**(2025-2028 он)**

**2025 он**



## НЭГ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Өнөө цаг үед хурдацтай өөрчлөгдөж буй нийгэм, эдийн засгийн орчин, технологийн дэвшил, хэрэглэгчийн хүлээлт, олон улсын чиг хандлага нь байгууллагын үйл ажиллагаа, менежмент, төлөвлөлтийн арга барилд шинэчлэл хийх шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна.

Байгууллага нь өөрийн эрхэм зорилго, үнэт зүйл, хөгжлийн зорилтуудаа тодорхойлон, урт хугацааны тогтвортой, уялдаа холбоотой, үр дүнтэй үйл ажиллагаа явуулахын тулд стратегийн төлөвлөлт зайлшгүй шаардлагатай байдаг.

Энэхүү стратеги төлөвлөгөө нь байгууллагын дотоод нөөц бололцоо, гадаад орчны нөлөөллийг харгалзан, цаашдын хөгжлийн чиг хандлага, зорилтот үр дүнг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамж болох юм. Мөн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлж, үр ашигтай, ил тод, хариуцлагатай тогтолцоог төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний өсөлт нь мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна.

Ялангуяа технологийн хурдацтай хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн олон улсын өрсөлдөөн нь үндэсний хэмжээний ур чадвар бүхий ажилтан бэлтгэхэд шинэ хандлага, арга зүй нэвтрүүлэхийг шаардаж байна.

Тус сургууль нь эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дотоод нөөц, багшийн тасралтгүй хөгжил, сургалтын хөтөлбөрийн чанар, хүртээмж, сургалтын орчин, менежмент, нийгмийн түншлэлийн хамтын ажиллагааг цогцоор нь хөгжүүлэх шаардлагатай байдаг.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Өвөрхангай аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад холбогдох хууль, тогтоомж, салбарын болон бүс нутгийн хөгжлийн бодлого, дүн шинжилгээ, байгууллагын өмнөх төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, сургуулийн үйл ажиллагаанд оролцогч талуудын саналыг үндэслэн боловсруулав.

Энэхүү стратеги төлөвлөгөө нь байгууллагын хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох, чанартай боловсрол олголтыг дэмжих, тогтвортой хөгжлийн зорилтод хувь нэмэр оруулах чухал баримт бичиг тул байгууллагын болон албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд зөв бодлого, хандлага чиглэл, сэтгэлгээ, удирдлага, зохион байгуулалт, арга барил, ур чадвар, үр дүнг бий болгоход оршино.

Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжсэн бөгөөд Засгийн газрын 2020 оны 216

дугаар тогтоол “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2 дугаар хавсралт “Стратеги төлөвлөгөөний загвар”-ын дагуу байгууллагын 2025-2028 онд хэрэгжүүлэх байгууллагын мандат, алсын хараа, эрхэм зорилго, орчны шинжилгээ, стратегийн зорилго, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, арга замыг тодорхойлсон баримт бичгийг боловсрууллаа.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа сургуулийн багш, ажилтнууд, суралцагчид болон түншлэгч байгууллагууд, ажил олгогч нараас хэд хэдэн удаагийн санал авч, гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг Филиппин улсын Манила хотын Гонзалесийн дурсгалын дүрслэх урлаг, гар урлалын сургууль, TESDA Эмэгтэйчүүдийн төв, Дон Боско техникийн коллеж, Холбооны бүгд найрамдах Герман улсын мэргэжлийн сургуулиуд, Франц улсын Аллиер мужийн мэргэжлийн сургууль, дотоодын Ховд хөгжил Политехник коллеж зэргийн хөтөлбөрүүдтэй дотоодын болон олон улсын харьцуулалт хийн, сайн туршлагыг судлан, Захирлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, баримт бичигт тусгаж ажилласан болно.

---o0o---

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

*Мандатын шинжилгээний хүснэгт:*

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		Боловсролын яамны харьяа Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж нь үйл ажиллагаандаа 50 хуулийг мөрдлөг болгон, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг олгон, мэргэжилтэй ажилтанг бэлтгэж байна.
Үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо: <b>24</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль;</li> <li>2. Биеийн тамир спортын тухай хууль;</li> <li>3. Боловсролын ерөнхий хууль;</li> <li>4. Галын аюулгүй байдлын тухай хууль;</li> <li>5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;</li> <li>6. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тухай хууль;</li> <li>7. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль;</li> <li>8. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль;</li> <li>9. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хууль;</li> <li>10. Нийгмийн даатгалын тухай хууль;</li> <li>11. Номын сангийн тухай хууль;</li> <li>12. Патентын тухай хууль;</li> <li>13. Соёлын тухай хууль;</li> <li>14. Статистикийн тухай хууль;</li> <li>15. Тариалангийн тухай хууль</li> <li>16. Усны тухай хууль;</li> <li>17. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;</li> <li>18. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;</li> <li>19. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль;</li> <li>20. Хөдөлмөрийн тухай хууль;</li> <li>21. Хүүхэд хамгааллын тухай хууль;</li> <li>22. Эрүүгийн тухай хууль;</li> <li>23. Эрүүл ахуйн тухай хууль;</li> <li>24. Эрүүл мэндийн тухай хууль;</li> </ol>
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо: <b>26</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Авилгын эсрэг хууль;</li> <li>2. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;</li> <li>3. Аудитын тухай хууль;</li> <li>4. Байгууллагын нууцын тухай хууль;</li> <li>5. Газрын тухай хууль;</li> <li>6. Гамшгийн тухай хууль;</li> <li>7. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль;</li> <li>8. Зөрчлийн хууль;</li> <li>9. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль;</li> <li>10. Иргэний хууль;</li> <li>11. Монгол Улсын Үндсэн хууль;</li> <li>12. Монгол хэлний тухай хууль;</li> <li>13. Мэдээллийн ит тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;</li> <li>14. Нийгмийн даатгалын тухай хууль;</li> <li>15. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонихрлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;</li> <li>16. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;</li> <li>17. Онц байдлын тухай хууль;</li> <li>18. Соёлын тухай хууль;</li> <li>19. Тамхины хяналтын тухай хууль;</li> <li>20. Татварын тухай хууль;</li> <li>21. Төрийн албаны тухай хууль;</li> <li>22. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;</li> <li>23. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;</li> <li>24. Төрийн хяналт шалгалтын тухай хууль;</li> </ol>

		<p>25. Төсвийн тухай хууль;  26. Тэтгэврийн тухай хууль;  27. Усны тухай хууль;  25. Хог хаягдлын тухай хууль;  28. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;  29. Хувь хүний нууцийн тухай хууль;  30. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;  31. Цэргийн албаны тухай;  32. Шилэн дансны тухай хууль;  33. Шуудангийн тухай хууль;  26. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;</p>
<b>Ерөнхий чиг үүрэг-1: Сургуулийн хөгжлийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.</b>		
<b>Үндсэн чиг үүрэг</b>	<b>Дэд чиг үүрэг</b>	<b>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</b>
ҮЧҮ-1: Сургуулийн хөгжлийн бодлого төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг тасралтгүй хөгжүүлэх	Байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөртэй нийцүүлэн төлөвлөх	Албаны менежерүүд, дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ахлах ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах ажилтан, хүний нөөц, эрх зүй хариуцсан ажилтан, захирлын туслах, архив албан хэрэг хөтлөлтийн ажилтан
ҮЧҮ-2 Чанарын баталгаажилтын тогтолцоог хөгжүүлэх, дотоодын эрх бүхий байгууллагаар хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэх	Сургуулийн чанарын баталгаажилтын тогтолцоог сайжруулж, сургалтын чанар, сургуулийн дотоод үйл ажиллагаа болон хөндлөнгийн байгууллагын үнэлгээг үндэслэн чанарын шинэчлэл, тогтмол хяналт хийж, сургуулийн үйл ажиллагааг үр дүнтэй, үр ашигтай болгох	Чанарын баталгаажилт, дотоод хяналтын менежер, дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ахлах ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн, сургалтын арга зүйч нар, хүний нөөц эрх зүй хариуцсан ажилтан,
ҮЧҮ-3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх	Сургуулийн багш ажилтнууд, суралцагчдын аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, аюулгүй сургалтын орчин, ажлын байрыг бий болгох	
<b>Ерөнхий чиг үүрэг-2: Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын стандартад нийцсэн чанартай сургалт, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.</b>		
ҮЧҮ-1: Сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах	Иргэний мэргэжил, ур чадвар эзэмших хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн чанартай боловсрол, сургалтын үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, тэгш хамруулах тухайн орон нутаг, бүс нутгийн бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлэх	Сургалтын менежер, арга зүйч-багш, багш нар

	Сургалтын чанар, хүртээмжийг сайжруулж, суралцагчдад өндөр чанартай, тэгш боломж бүхий сургалтын орчин, агуулга, арга зүйг хүргэх замаар боловсролын түвшинг нэмэгдүүлэх	
ҮЧҮ-2: Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын элсэлт, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар олон нийтэд бодит, цогц мэдээлэл хүргэж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын хэрэгцээнд нийцсэн мэргэжлүүдийг тодорхойлж, сургалтын хөтөлбөр, элсэлтийн бодлогыг төлөвлөх	Сургалтын менежер, нийгмийн түншлэлийн арга зүйч нар, арга зүйч-багш, багш нар
	Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, тэдний сонирхол, авьяас, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан зөв мэргэжил сонгоход нь дэмжлэг үзүүлэх.	
	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор ажил олгогч, төгсөгч болон сургалтын байгууллагын хоорондын эргэх холбоог бэхжүүлэх	
	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, орон нутгийн онцлогт нийцсэн богино хугацааны сургалтыг зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн боломжийг нэмэгдүүлэх, иргэдийн ур чадварыг дээшлүүлэх	
<b>Ерөнхий чиг үүрэг-3: Суралцагчдын энтрепренерд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрийн соёлыг төлөвшүүлнэ.</b>		
ҮЧҮ-3.1: Суралцагч бүрийн оролцох эрхэд дэмжлэг үзүүлэн, хөгжлийн түвшинг нэмэгдүүлэх	Суралцагч бүр сургалтын байгууллагын орчинд амар тайван суралцах, хүний эрхийг дээдэлсэн тэгш, хүртээжтэй, эрүүл аюулгүй, суралцах жендерийн мэдрэмжтэй нөхцөлийг бүрдүүлэх	Сургалтын менежер, нийгмийн ажилтнууд, номын санч, эмч, дотуур байрын багш нар, багш нар
ҮЧҮ-3.2: Хүүхдийн эрхийг дээдлэх, хүндэтгэх тэгш боломжоор хангах, суралцах эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх, бүх шатны боловсрол олгох бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх	Сургалтын менежер, нийгмийн ажилтнууд, номын санч, эмч, дотуур байрын багш нар, багш нар
	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орчин, нөхцөл бүрдүүлэх	

<b>Ерөнхий чиг үүрэг-4: Түншлэлийн интеграцийг хөгжүүлж, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.</b>		
ҮЧҮ-1: Нийгмийн түншлэлийн дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, ажил олгогч, түншлэгч байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх	Түншлэгч байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх, түншлэл хоорондын интеграц хийх	Сургалтын менежер, нийгмийн түншлэлийн арга зүйч нар, арга зүйч-багш нар, багш нар
	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн багш, суралцагчдын мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх	
ҮЧҮ-2: Нийгмийн түншлэлийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх	Багш, ажилтан, суралцагчдыг гадны ижил төстэй байгууллагад мэргэжлийн дагуу дадлагажуулж, мэргэжлийн ур чадвар, чадварлаг багшлах арга барил, хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадварыг олгох	Захиргаа, аж ахуйн менежер, Хэвлэл мэдээлэл, гадаад харилцаа хариуцсан ажилтан
	Олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг байгууллагуудтай харилцаа тогтоон, шаардлагатай санхүүгийн болон техник технологийн дэмжлэг авах	
<b>Ерөнхий чиг үүрэг-5: Сургуулийн үйл ажиллагааны тогтвортой, ногоон, жендэрийн мэдрэмжтэй, энтрепренер, хайбрид нөөцийг төлөвлөж, бүрдүүлж, хөгжүүлнэ.</b>		
ҮЧҮ-1: Хүний нөөцийн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах	Хүний нөөцийг оновчтой бүрдүүлж, тасралтгүй хөгжүүлэх	Захиргаа, аж ахуйн менежер, хүний нөөц, эрх зүй хариуцсан ажилтан
	Багш, ажилтнуудын нийгмийн баталгааг ханган, чадавхыг бэхжүүлэх	
ҮЧҮ-2: Сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдах орчин нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн менежментийг төлөвшүүлэх	Сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдах сургалтын орчинг тогтмол сайжруулах	Захиргаа, аж ахуйн менежер, ерөнхий нягтлан бодогч, эдийн засагч, тооцооны нягтлан бодогч, нярав
	Санхүүгийн бодлого, санхүүгийн төлөвлөлт болон ил тод байдлыг сайжруулж, санхүүгийн удирдлагын үр ашгийг дээшлүүлэх, ил тод мэдээлэл, тайлагналын систем-ийг хэрэгжүүлж, санхүүгийн шилжилт, хөгжлийг дэмжих	

## **ГУРАВ. АЛСЫН ХАРАА**

Олон улсын жишигт нийцсэн, үндэсний тэргүүлэгч сургалт, үйлдвэрлэлийн байгууллага болох

## **ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО**

Бид хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, өрсөлдөх чадвартай, мэргэжлийн өндөр ёс зүй ур чадвар бүхий үндэсний мэргэжилтэй ажилтанг бэлтгэнэ.

### **ҮНЭТ ЗҮЙЛ**

- Тогтвортой, ногоон хөгжил
- Жендэрийн мэдрэмж
- Ил тод, шударга, тэгш, хүртээмж
- Гүйцэтгэлд суурилсан чанар, хариуцлага
- Өргөтгөсөн чадавх, түншлэлийн интеграц
- Инновац, бүтээлч, өсөлтийн сэтгэлгээ

### **УРИА**

- Чанартай орчин
- Чадварлаг багш
- Чадамжтай мэргэжилтэн
- Чинээлэг амьдрал

## ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээний хүснэгт:

Давуу тал (S)	Сул тал (W)
<ul style="list-style-type: none"> <li>- Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй зохион байгуулдаг.</li> <li>- Чадварлаг хүний нөөцтэй.</li> <li>- Сургуулийн нийт багш нарын 76% нь мэргэжлийн зэрэгтэй, дадлага туршлагатай бөгөөд ажиллах орчиндоо шинэ технологиудыг нэвтрүүлж, сайжруулалт хийх боломжтой.</li> <li>- Дэд хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн.</li> <li>- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө нь стандартад нийцсэн, чанарын хяналт, үнэлгээ, судалгааг тогтмол хийдэг нь сургалтын үр нөлөөг нэмэгдүүлдэг.</li> <li>- Орчин үеийн шаардлагад нийцсэн цахим сургалтын орчны дэд бүтэцтэй бөгөөд хичээлээ цахимаар явуулах нөхцөл боломж бүрдсэн.</li> <li>- Сургуулийн материаллаг бааз, орчин сайтай.</li> <li>- Суралцагчдын хөгжил, хамгаалалд анхааран ажиллаж, олон талт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж хэвшсэн.</li> <li>- Нийгмийн түншлэлийн хамтын ажиллагааг бэхжүүлсэн.</li> <li>- Аймаг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай уялдаа, холбоотой ойр ажилладаг.</li> <li>- Олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөрт хамрагддаг.</li> <li>- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бүхий л чиглэлээр анхааран ажилладаг.</li> <li>- Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж хэвшсэн.</li> <li>- Үйлдвэрлэл дээр багш нарыг чадавхжуулж, туршлага судлуулахад анхаарч ажилладаг.</li> <li>- Багш, ажилтнуудын ажлын байран дээр тогтмол хөгжүүлэхэд анхааран ажилладаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Багшийн цалин инженер техникийн ажилтны цалингаас бага байгаагийн улмаас мэргэжлийн багш нар дутагдалтай.</li> <li>- Багшийг дэмжих урамшууллын тогтолцоо ЕБ-ын сургуулиас бага байдаг тул ерөнхий эрдмийн зарим мэргэжлийн багш нар дутагдалтай.</li> <li>- Архивын өрөөний зай бага, цахим архивын програм хангалтгүй байгаа тул албан хэрэг хөтлөлт, мэдээллийн хадгалалт, хуваарилалтад саатал гарч болзошгүй.</li> <li>- Төрөөс бодлогоор дадлагын газрыг сүүлийн үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангадаггүй</li> </ul>
Боломж (O)	Эрсдэл (T)
<ul style="list-style-type: none"> <li>- Сургуулийн гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улсын сургалтын хөтөлбөрийг судлах, туршлага солилцох боломжууд байгаа нь сургуулийн сургалтын чанарыг олон улсын стандарттай ойртуулна.</li> <li>- Аймаг, орон нутгийн удирдлагуудтай хамтран төсөл хөтөлбөрийн дэмжлэг авч сургалтын орчныг сайжруулах боломжтой.</li> <li>- Мэргэжлийн болон магистрын зэрэгтэй багш нарыг нэмэгдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх боломж бий.</li> <li>- Мэргэжлийн хөтөлбөрүүдийг олон улсад магадлан итгэмжлүүлэх боломж нь сургуулийн нэр хүндийг өсгөх, суралцагчдад илүү өргөн сонголттой сургалт олгоход тусална.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Боловсролын бодлого, хууль тогтоомжид гарч буй өөрчлөлтүүд нь сургуулийн бүтэц, удирдлагын тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй.</li> <li>- Санхүүжилтын хязгаарлагдмал байдал нь сургалтын материаллаг баазын шинэчлэлт, багшлах боловсон хүчний хөгжилд сөргөөр нөлөөлж, хөтөлбөрийн чанарт нөлөөлөх эрсдэлтэй.</li> <li>- Хөдөлмөрийн зах зээл дээр шинэ, сүүлийн үеийн ур чадвар шаардлагатай байгаа нь сургуулийн хөтөлбөрт эргэлт хийх хэрэгцээг нэмэгдүүлж байна.</li> <li>- Орон нутагт ажиллах мэргэжилтэй багш, ажилтны хомсдол тулгамдаж, шинэ мэргэжилтнүүдийг татахад хүндрэлтэй байна.</li> </ul>

## ГАДААД ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Монгол улсын болон аймаг орон нутгийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтөд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг тэргүүлэх чиглэлээр хөгжүүлэхээр төлөвлөн, Монгол улсын бүтээн байгуулалтад ажиллах ур чадвартай мэргэжилтэй ажилтанг бэлтгэхэд анхаарч, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийг шинэчлэн мэргэшлийн үндэсний хүрээ, чанарын баталгаажилтын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэж, мэргэжлийн боловсрол сургалтын үнэ цэнийг нэмэгдүүлж байгаа нь чадамжтай мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлж байна.

Орчны шинжилгээний үр дүнгээс харахад тус сургууль нь чадварлаг хүний нөөцийг бүрдүүлсэн, сургалтын чанарт анхаарч ахиц дэвшил гарган, интеграц хийсэн, цахим дэд бүтэцтэй, нийгмийн түншлэл, олон улсын хамтын ажиллагаа зэрэг тогтвортой давуу талуудтай байгууллага болох нь харагдаж байна. Энэ нь байгууллагын үйл ажиллагааны чанар хүртээмж, үйлчилгээний чанарт эерэгээр нөлөөлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байна.

Сургуулийн хувьд сургалтын бааз суурь, тоног төхөөрөмж сайтай ч дадлагын газруудын тоног төхөөрөмж орчин үеийн шаардлагыг хангахгүй дутмаг, багш нарын цалин хангамж инженерийн цалингаас бага байгаагаас мэргэжлийн багшийн хомсдолд орж байгаа зэрэг сул талууд нь сургалтын үр өгөөжид сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Гадаад орчны хувьд олон улсын болон орон нутгийн хамтын ажиллагаа, бодлогын дэмжлэг сайтай, мэргэшсэн багш бэлтгэх боломж бүрдсэн, магадлан итгэмжлэлээр дамжуулан байгууллагын болон хөтөлбөрийн чанарыг сайжруулах боломж байгаа нь харагдаж байна. Орчны давуу тал, боломжийг үр ашигтай ашиглаж, сул тал, эрсдэлийг бууруулах бодлого, үйл ажиллагааны стратегийг төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй юм.

Бид гадаад дотоод орчны шинжилгээнээс үндэслэн сургалтын чанар хүртээмж, шаталсан сургалтын хөтөлбөрийг нэмэгдүүлэх, суралцагчдын мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд анхаарах, хүний нөөцийн инновацийн бүтээлч хөгжлийг тасралтгүй дэмжих, мэргэжлийн боловсрол, сургалтын үнэ цэнэ, үнэлэмжийг нэмэгдүүлэх, гадаад дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх, материаллаг нөөц баазыг сайжруулан, чанарын соёлыг төлөвшүүлэх, инновац шингэсэн бүтээгдэхүүн бий болгох, судалгаа, шинжилгээний ажлыг ахисан түвшинд гаргах, мэргэжил хоорондын интеграц хийх зэрэгт онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байна. Иймд орчны шинжилгээнд үндэслэн сургуулийн энэхүү стратеги төлөвлөгөөг 4 жилийн хугацаатайгаар боловсруулсан болно.

## **ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО**

Тогтвортой, ногоон, жеңдэрийн мэдрэмжтэй, энтрепренер, хайбрид сургалтын хөтөлбөр, нөөцийн хөгжүүлэлтийг өсгөн, суралцагчийн эрхийг хангаж, түншлэлийн интеграцийг бэхжүүлэх замаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, өргөтгөсөн чадавх бүхий төгсөгчийг бэлтгэн, байгууллагад ёс зүй, гүйцэтгэлд суурилсан чанарын баталгаажилт, соёлыг төлөвшүүлэхэд оршино.

### **ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ**

#### **Дээд шатны байгууллага:**

- Боловсролын яам;
- Боловсролын ерөнхий газар;

#### **Мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилладаг байгууллага:**

- Боловсролын үнэлгээний төв;
- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл;
- Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн Удирдах зөвлөл;
- Мэргэжлийн холбоод, олон улсын байгууллагууд;

#### **Орон нутагт хамтран ажилладаг байгууллага:**

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал;
- Аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар;
- Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс;
- Аймгийн Боловсролын газар;
- Өвөрхангай аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар;
- Худалдаа аж үйлдвэрийн танхимын Өвөрхангай аймаг дахь салбар;
- Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо;
- Үйлдвэрчний эвлэл;
- Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Засаг даргын тамгын газар;
- Түншлэгч байгууллагууд;
- Бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага;

### **НАЙМ. ХАВСРАЛТ ХОЛБОГДОХ МАТЕРИАЛ**

- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль;
- Боловсролын ерөнхий хууль;
- Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн өмчийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хүүхэд хамгааллын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоол “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”;
- Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол “Стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”;
- Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал” 2 дугаар хавсралт “Стратеги төлөвлөгөөний загвар”;
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал;

- Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт;
- Өвөрхангай аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл;
- Өвөрхангай аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Өвөрхангай аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа-2018;
- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2025);
- Шинэ сэргэлтийн бодлого;
- [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn);
- [www.cabinet.gov.mn](http://www.cabinet.gov.mn);
- [www.mlsp.gov.mn](http://www.mlsp.gov.mn);
- [www.uvurkhangai.gov.mn](http://www.uvurkhangai.gov.mn);
- [www.1212.mn](http://www.1212.mn);
- [www.uv-college.edu.mn](http://www.uv-college.edu.mn);

---o0o---

## ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2028 ОН)

Төлөвлөгөөг баталсан:

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

(албан тушаал)



Төсвийн Шууд захирагч

САРАЙСАНДАМБЫН САНЧИР

2025.10.06

(огноо)

Төлөвлөгөө боловсруулсан:

ЧАНАРЫН БАТАЛГААЖИЛТ, ДОТООД ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

(албан тушаал)

Төрийн албан хаагч

БАТБОЛДЫН ХУЯГМАА

2025.10.06

(огноо)

Тэмдэг

**БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ХАРЬАА МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ**

Бодлогын баримт бичиг тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр (мянган төгрөг)
<b>Ерөнхий чиг үүргийн нэр: Ерөнхий чиг үүрэг-1: Сургуулийн хөгжлийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээ, үйлчилгээний чанар, хүргээмжийг сайжруулна.</b>					
<b>Үндсэн чиг үүргийн нэр: Сургуулийн хөгжлийн бодлого төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг тасралтгүй хөгжүүлэх</b>					
<b>Зорилт-1</b> Байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөртэй нийцүүлэн төлөвлөх	Улсын болон орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан сургуулийн бодлого, хөтөлбөр дүрэм, журмыг шинэчлэх	Сургуулийн хэмжээнд мөрдөгдөж буй бодлого, хөтөлбөр, дүрэм журмыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх 2025 онд 3-аас доошгүй бодлого, хөтөлбөр, дүрэм журам 2026 онд 5-аас доошгүй бодлого, хөтөлбөр дүрэм, журам 2027 онд 5-аас доошгүй бодлого, хөтөлбөр, журам 2028 онд 5-аас доошгүй бодлого, хөтөлбөр дүрэм, журам	2024 онд 1 дэд хөтөлбөр, 8 дүрэм, журмыг шинэчлэн, хэрэгжүүлэн, дүрэм журмын эмхтгэлийг шинэчилсэн.	Улсын болон аймаг, орон нутгийн бодлого хөтөлбөртэй нийцүүлэн, сургуулийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	2000,0 мянган төгрөг
	Сургуулийн эрх ашгийг хамгаалах, нийгэм дэх нэр хүндийг өсгөх	Сургуулийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэргэжлийн боловсролын үнэ цэнэ, үнэлэмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр арга хэмжээг зохион байгуулах 2025 онд: 5-аас доошгүй арга хэмжээ 2026 онд: 5-аас доошгүй арга хэмжээ 2027 онд: 8-аас доошгүй арга хэмжээ 2028 онд: 10-аас доошгүй арга хэмжээ	Сургуулийн үйл ажиллагааг вэбсайт болон хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан.	Сургуулийн эрх ашгийг хамгаалж, нийгэм дэх эерэг төсөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын үнэ цэнэ үнэлэмжийг нэмэгдүүлж ажилласан байна.	20000,0 мянган төгрөг

Үндсэн чиг үүрэг: Чанарын баталгаажилтын тогтолцоог хөгжүүлэх, дотоодын эрх бүхий байгууллагаар хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэх					
					5000,0 төгрөг мянган
<b>Зорилт-1.</b> Сургуулийн чанарын баталгаажилтын тогтолцоог сайжруулж, сургалтын чанар, сургуулийн дотоод үйл ажиллагаа болон хөндлөнгийн байгууллагын үнэлгээг үндэслэн чанарын шинэчлэл, тогтмол хяналт хийж, сургуулийн үйл ажиллагааг үр дүнтэй, үр ашигтай болгох	Сургуулийн чанарын баталгаажилтын тогтолцоог сайжруулах	Сургалтын үйл ажиллагааны чанар хуртээмжийг сайжруулах дотоод хяналт шинжилгээ, үнэлгээг зохион байгуулан чанарын баталгаажилтыг төлөвшүүлэх - 2025 онд 25 удаа - 2026 онд 25 удаа - 2027 онд 27 удаа - 2028 онд 27 удаа	2024 онд 25 удаагийн дотоод хяналт шинжилгээ үнэлгээг зохион байгуулан, ажил үйлчилгээг сайжруулан ажилласан.	Сургуулийн дотоод чанарын баталгаажилтын тогтолцоо болон хөндлөнгийн үнэлгээний үндсэн чанарын дээр сайжруулалтыг хийж, сургалтын чанар, удирдлагын үр ашигтай, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.	240,000,0 төгрөг мянган
<b>Зорилт-2.</b> Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх	Сургуулийн багш ажилтнууд, суралцагчдын аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, аюулгүй	Байгууллага болон хөтөлбөрт дотоод, гадаадын хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хийлгэх 2025 онд: 4 хөтөлбөрийн хөндлөнгийн чанарын баталгаажилт хийлгэх 2026 онд: Байгууллагын олон улсын хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хийлгэх 2027 онд: 5 хөтөлбөрийн хөндлөнгийн баталгаажуулалтыг хийлгэх 2028 онд: 5 хөтөлбөрийн хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг хийлгэх	2024 онд 2 дахь удаагаа байгууллагын магадлан итгэмжлэл хийлгэсэн.	Дотоодын болон олон улсын хөндлөнгийн байгууллагаар чанарын баталгаажилт хийлгэж, чанарын соёлыг төлөвшүүлнэ.	20000,0 төгрөг мянган

	сургалтын орчин, ажлын байрыг бий болгох	2026 онд: Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хяналтын тогтолцоог бий болгож хэвшүүлэх 2027 онд: ХАБЭА-н удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх 2028 онд: 10-аас доошгүй удаагийн арга хэмжээ зохион байгуулах	байрын эрсдэлийн үнэлгээг хийж, бууруулж ажиллана.	
<b>Ерөнхий чиг үүргийн нэр: Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын стандартад нийцсэн чанартай сургалт, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.</b>				
<b>Үндсэн чиг үүргийн нэр: Сургалтын чанар хүртээмжийг сайжруулах</b>				
